



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/165

Улаанбаатар хот

┌ Монголын оюутны спортын VI наадмын ┐
нэгдсэн заавар батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах тухай журам”-ын 2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын оюутны спортын VI наадмын нэгдсэн зааврыг хавсралтаар баталсугай.

2. Наадмын зохион байгуулалтыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган явуулж, тайланг II улиралд багтаан танилцуулахыг Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэст даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142410177

Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2024 оны 07 дугаар сарын 06 ны
өдрийн 07 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛЫН ОЮУТНЫ СПОРТЫН VI НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

Нэг. Зорилго

Оюутны бие бялдрын боловсролыг нэмэгдүүлэх, тэдний дунд спортыг хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, оюутны тив, дэлхийн тэмцээн, наадамд өрсөлдөх тамирчдыг сонгон шалгаруулахад Монголын оюутны спортын VI наадмын зорилго оршино.

Хоёр. Наадмын удирдлага, зохион байгуулалт

Наадмыг улсын хэмжээнд Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо, Боловсрол, шинжлэх ухааны яам, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, Монголын оюутны спортын холбоо, Их, дээд сургуулиуд, спортын холбоод удирдан зохион байгуулна.

Наадмын анхан шатны тэмцээнийг нэгдсэн зааварт тусгагдсан спортын төрлүүдээр Их, дээд сургуулийн захиргаа, биеийн тамирын тэнхим, спорт клуб, оюутны холбоо хамтран зохион байгуулна.

Наадмын шигшээ тэмцээнийг Монголын оюутны спортын холбоо зохион байгуулна. Байршил, хаяг, утас: Улаанбаатар хот, Бага тойруу-55, Спортын төв ордон, 2 давхрын 204/А тоот өрөө, 264136, 311947, 99063275, 88002982, erdenetuya07@gmail.com, dookhuuc@gmail.com, www.sport.gov.mn, www.mssf.mn, Монголын оюутны спортын холбоо /Mongolian student sports federation фейсбүүк хуудсаар харилцана.

Гурав. Наадмын үе шат, хугацаа, спортын төрөл

Наадмын тэмцээнийг бүх хэвшлийн их, дээд сургууль, салбар сургуулиуд болон бүрэлдэхүүн сургуулиудын оюутны дунд нэгдсэн зааврын дагуу зуны спортын 10 төрлөөр 2 үе шаттайгаар зохион байгуулна.

1. Волейбол
2. Гандбол
3. Жүдо бөх
4. Сагсан бөмбөг 5х5
5. Таеквондо
6. Футзал
7. Чирлидинг
8. Чөлөөт бөх
9. Шатар
10. Ширээний теннис.

Анхан шат: Монгол Улсын бүх хэвшлийн их, дээд сургууль, салбар сургуулиуд болон бүрэлдэхүүн сургуулиуд 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

Шигшээ наадам: Анхан шатны тэмцээнээс шалгарсан баг тамирчдын дунд 2024 оны 04 дүгээр сарын 15-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо шигшээ наадмыг зохион байгуулна.

Дөрөв. Наадамд оролцогчдод тавигдах шаардлага, насны хязгаар

Бүх хэвшлийн их, дээд сургуулийн өдрийн ангид суралцдаг, дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэлтэй 1999 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төрсөн 18-25 насны оюутан, Монгол Улсын иргэн оролцоно. Наадамд оролцогч оюутан нь тухайн Их, дээд сургуульд нэгээс доошгүй хичээлийн улирал суралцсан байна.

Оюутны спортын наадамд нэг тамирчин нэг спортын төрөлд оролцоно.

Нийслэлд үйл ажиллагаагаа явуулдаг Их, дээд сургуулийн харьяа болон салбар сургуулиуд нь төв сургуулийн аварга шалгаруулах тэмцээндээ орж, шалгарсан баг тамирчид шигшээ тэмцээнд оролцоно.

Орон нутагт байрладаг Их, дээд сургуулийн харьяа сургуулийн баг, тамирчид нь наадамд бие даан оролцож болох бөгөөд төв сургуулиа төлөөлөн наадмын шигшээ тэмцээнд оролцохгүй.

Наадмын анхан шат, шигшээ тэмцээнийг зохион байгуулах байгууллага нь оролцогчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, спортын заал, талбайн хэвийн үйл ажиллагаа, хэв журмын болон спортын бус зан авир, зөрчил гаргуулахгүй байх, эерэг хандлага, ёс зүйтэй байх бүхий л арга хэмжээг авч ажиллах ба багууд нь оролцогч тамирчдын эрүүл мэндийн даатгал, эмчийн үзлэгийг бүрэн хариуцна.

Наадамд оролцож буй Их, дээд сургуулийн багууд нь өөрсдийн сургуулийн онцлогийг илэрхийлсэн бэлтгэлийн болон тоглолтын жигд хувцастай, сургуулийн нэр, логотой 80см x 120см хэмжээтэй тугтай байна.

Тав. Мэдүүлэг хүлээн авах хугацаа, оролцох журам

Бүх хэвшлийн их, дээд сургуулиуд нь спортын төрлийн анхан шатны тэмцээн зохион байгуулагдаж дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан баталгаажуулсан тэмцээний тайлан, протокол, шалгарсан баг тамирчид, дасгалжуулагчдын мэдүүлэг, мэдээллийг Монголын оюутны спортын холбоонд ирүүлнэ.

Монголын оюутны спортын холбоо нь бүх хэвшлийн их, дээд сургуулиудаас ирүүлсэн анхан шатны тэмцээний баталгаажсан тайлан, протокол, мэдүүлэг, мэдээллийг үндэслэн шигшээ шатанд шалгарсан баг тамирчид, дасгалжуулагчдын овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, 3x4 хэмжээтэй цээж зураг, оролцох спортын төрлийн зай, жин, сургуулийн нэр, өмнөх шатны тэмцээнд эзэлсэн байр зэрэг мэдээллийг наадмын цахим мэдээллийн cpanel.sport.gov.mn санд онлайнаар бүртгэнэ.

Шигшээ наадамд баг, тамирчдын цахим бүртгэлтэй холбоотой сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 10.00 цагт Биеийн тамир спортын улсын хорооны хурлын танхимд зохион байгуулна.

Наадмын Зохион байгуулах хорооноос наадмын цахим мэдээллийн cpanel.sport.gov.mn санд бүртгэсэн баг тамирчдын цахим бүртгэлийг "БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ"-ээр хянан баталгаажуулна.

Уг баталгаажуулагдсан мэдээллийн дагуу шигшээ наадамд оролцогчдын мандат наадмын цахим сангаас гарч, спортын төрөл тус бүрийн техникийн зөвлөгөөн дээр олгогдоно.

Онлайн бүртгэлд ороогүй, албан ёсны мэдүүлэггүй, мэдүүлгийг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн дотор өгөөгүй, хожимдуулсан, бичиг баримт, материалын бүрдүүлэлт дутуу нөхцөлд наадмын бүртгэлийн комиссоос мандатыг олгохгүй. Мөн наадмын бүртгэлийн комиссын шаардсан материал, оюутны мэдээллээ үнэн зөв бөглөн, авч ирээгүй тохиолдолд мандат олгохгүй.

Наадамд оролцогч нь олон улсын тэмцээний дүрмийн дагуу зааварт тусгагдсан төрөл, зай, жингээр оролцоно.

Тамирчны нас, хүйс, овог нэр, харьяаллын болон бусад зөрчил илэрсэн тохиолдолд шигшээ тэмцээнд оролцуулахгүй бөгөөд хэрэв дээрх зөрчилтэйгөөр наадамд оролцож, илэрсэн тохиолдолд тухайн тэмцээний амжилтыг хүчингүйд тооцон дараагийн эрэмбэлэгдсэн тамирчин, багт шагналыг шилжүүлнэ.

Зургаа. Наадмын хүрээнд хийх ажлын чиглэл

Наадмын үе шатуудад бүх хэвшлийн их, дээд сургуулиуд нь өөрийн сургуулийн онцлогт тохируулан дараах арга хэмжээг авч явуулна.

- Сургууль тус бүр анхан шатны тэмцээн зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах;
- Наадмын анхан шат, шигшээ тэмцээнийг зохион байгуулах болон шалгарсан баг тамирчдыг бэлтгэн оролцуулахтай холбоотой төсвийг батлан гаргах;
- Сургууль бүр оюутнуудыг олноор нь хамруулсан хэлбэрээр анги, салбар, бүрээс төрөл тус бүрд хэд хэдэн баг гарган аль болох нийтийг хамарсан төрлүүдээр тэмцээн зохион байгуулах;
- Нийслэл, аймаг, дүүргийн хэмжээнд сургууль хоорондын нөхөрсөг уулзалт тэмцээнийг өөрийн болон зочин багийн хэмжээнд олон баг оролцуулсан хэлбэрээр явуулах, үзэгчдийг татан оролцуулах;
- Оюутны спортын эрдэм шинжилгээний онол, практикийн бага хурал, семинар, зохион байгуулах, оюутны спортын гарын авлага, ном, товхимол гаргах;
- Сургууль бүр оюутны спортын өдөрлөг зохион байгуулах, нийтийг хамарсан арга хэмжээ хийх, материаллаг баазаа бэхжүүлэх, хэрэглэл материал худалдан авах, спорт заал, чийрэгжүүлэлтийн танхим, гадаа талбай байгуулах, тохижуулах;
- Оюутны эрүүл мэнд, бие бялдрыг дэмжсэн биеийн тамир, спортын төрөл бүрийн ажил, арга хэмжээ зохиох;

- Их, дээд сургуулийн дэргэдэх спортын клубийг шинэчлэн байгуулах, үйл ажиллагааг дэмжих, спортын шинэ төрөл хөгжүүлэх, секц нээн ажиллуулах хөдөлгөөн өрнүүлэх, алдартай оюутан тамирчдаа сурталчлах, алдаршуулах, наадмын спортын мэдээллийн байнгын булан гарган ажиллуулах;
- Оюутны спортын шигшээ баг тамирчдаа наадмын тэмцээнүүдэд амжилттай бэлтгэн, идэвхтэй оролцуулах төрөл бүрийн арга хэмжээ авах;
- Оюутны Универсад наадмын үзэл санааг сурталчлах, танхим шинээр байгуулах, ном материалыг авах, сурах бичигтэй болох;
- Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, Биеийн тамир, спортын газар, хороотой хамтарч сургуулийн оюутны спорт, биеийн тамир, спортын үйл ажиллагаа, арга хэмжээнд дэмжлэг туслалцаа авах, шигшээ тэмцээнд оролцуулах.

Дээрх арга хэмжээг зохион байгуулсан тухай тайланг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо болон Монголын оюутны спортын холбоонд ирүүлнэ.

Долоо. Наадмын тэмцээний заавар

1. Волейбол:

Нэг сургуулиас зөвхөн нэг баг оролцохыг зөвшөөрнө. Тэмцээнд нэг багт эрэгтэй 12, эмэгтэй 12 тамирчны бүрэлдэхүүнтэй, баг тус бүр 1 дасгалжуулагчтай оролцоно. Нийт багуудыг байр эзлүүлэх журмаар тэмцээнийг явуулна. Тоглолтын системийг техникийн зөвлөгөөн дээр танилцуулна. Тухайн спортын олон улсын тэмцээний дүрмийн дагуу зохион байгуулна.

2. Гандбол:

Нэг сургуулиас зөвхөн нэг баг оролцохыг зөвшөөрнө. Тэмцээнд нэг багт эрэгтэй 14, эмэгтэй 14 тамирчны бүрэлдэхүүнтэй, баг тус бүр 1 дасгалжуулагчтай оролцоно. Нийт багуудыг байр эзлүүлэх журмаар тэмцээнийг явуулна.

Тоглолтын системийг багийн тооноос хамаарч техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ. Хасагдах шат, шигшээ тоглолтод 2 баг тэнцсэн тохиолдолд баг бүрээс 5 тамирчин 7 метрийн торгуулийн цэгээс шидэлт хийж гүйцэтгэн ялагчийг тодруулна. Тухайн спортын олон улсын тэмцээний дүрмийн дагуу зохион байгуулна.

3. Жүдо бөх:

Тэмцээнд эрэгтэй: 60кг, 66кг, 73кг, 81кг, 90кг, 100кг, +100кг, эмэгтэй: 48кг, 52кг, 57кг, 63кг, 70кг, 78кг, +78кг олимпын жинд тус тус өрсөлдөнө. Жингийн зөрүү байхгүй.

Нэг жинд нэг ИДС-аас зөвхөн нэг тамирчин орно. Баг хариуцсан 2 дасгалжуулагчтай байна.

Дасгалжуулагч нь тэмцээний үеэр бэлтгэлийн хувцас өмсөх ба жин тус бүрийн медалийн төлөөх барилдаанд тамирчнаа дэвжээнд гаргахдаа костюм пиджак, цамц, зангиа зүүсэн байна. Тухайн спортын олон улсын тэмцээний дүрмийн дагуу зохион байгуулна.

4. Сагсан бөмбөг 5х5:

Нэг сургуулиас зөвхөн нэг баг оролцохыг зөвшөөрнө. Баг эрэгтэй 12, эмэгтэй 12 тамирчны бүрэлдэхүүнтэй, баг тус бүр 1 дасгалжуулагчтай байна. Тоглолтын системийг техникийн зөвлөгөөн дээр танилцуулна.

Тамирчдын хувцаслалт жигд байна. Тухайн спортын олон улсын тэмцээний дүрмийн дагуу зохион байгуулна. Нийт багуудыг байр эзлүүлэх журмаар тэмцээнийг явуулна.

5.Таеквондо:

Олимпын жингийн ганцаарчилсан тулааны төрлөөр тэмцээнийг явуулна. Ганцаарчилсан тулааны хугацаа: -1 мин 30 сек 3 үеийн турш явагдана. Тэмцээн эрэгтэй: 54кг, 58кг, -68кг, -80кг, +80кг жин, эмэгтэй: 46кг, 49кг, -57кг, -67кг, +67кг жинд тус тус өрсөлдөнө. Жингийн зөрүү байхгүй.

Сургуулиудаас нэг жинд 1 тамирчин оролцох бөгөөд эрэгтэй, эмэгтэй багууд 1 дасгалжуулагчтай байна. Тухайн спортын олон улсын дүрмийн дагуу зохион байгуулна.

6.Футзал:

Их, дээд сургуулиас зөвхөн нэг баг оролцохыг зөвшөөрнө. Баг нь эрэгтэй 10 тамирчин, 1 дасгалжуулагчийн бүрэлдэхүүнтэй оролцоно. Урьдчилсан тоглолт 10x10 минутын хугацаагаар явагдана. Сүүлчийн нэг минутыг цэвэр цагаар тооцно. Медалийн төлөө тоглолт 15x15 минутаар явна.

Нийт багуудыг байр эзлүүлэх журмаар тэмцээнийг явуулна. Хасагдах шатны тоглолтод 2 баг тэнцсэн тохиолдолд баг бүрээс 3 тамирчин 6 метрийн торгуулийн цэгээс цохилт гүйцэтгэж ялагчийг тодруулна. Тухайн спортын олон улсын дүрмийн дагуу зохион байгуулна.

7.Чирлидинг (Хөгжөөн дэмжигчдийн спорт):

Их, дээд сургууль тус бүрээс зөвхөн нэг баг оролцохыг зөвшөөрнө. Тэмцээнийг зөвхөн "Пом" (цацагтай) төрлөөр явуулна. Багийн бүрэлдэхүүнд 10 эмэгтэй тамирчин орно. Багт нэг дасгалжуулагч байна. Нийтдээ 11 хүн оролцохыг зөвшөөрнө. Тэмцээний өмнө тусгайлсан сургалтыг явуулж, дасгалжуулагч, шүүгч нарыг хамруулан оролцуулна. Багийн сугалааг техникийн зөвлөгөөн дээр хийнэ. Тэмцээнийг тухайн спортын олон улсын тэмцээний дүрмийн дагуу зохион байгуулна.

8.Чөлөөт бөх:

Тэмцээнд эрэгтэй: 57кг, 65кг, 74кг, 86кг, 97кг, 125кг жин, эмэгтэй: 50кг, 53кг, 57кг, 62кг, 68кг, 76кг жинд тус тус оролцоно. Жингийн зөрүү байхгүй. Нэг жинд нэг ИДС-аас зөвхөн нэг тамирчин орно.

9.Шатар:

Тэмцээн ганцаарчилсан ба багийн төрлөөр явагдана.

ИДС бүрээс эрэгтэй 2, эмэгтэй 1 тамирчин оролцоно. Багийн дүнг өндөр оноо авсан эрэгтэй 1, эмэгтэй 1 хоёр тамирчны хувийн төрөлд авсан онооны нийлбэрээр дүнг гаргана. Нэг сургуулиас нэг дасгалжуулагч баг хариуцан оролцуулна.

Тэмцээнийг 9 өрөгт багтаан швейцари системээр явуулна. Тоглолтын үеийн цагийн хяналт 1 цаг 30 минут, нэмэлт нүүдэл бүрт нэмэгдэл 30 секундээр тооцно. Тухайн спортын олон улсын дүрмийн дагуу зохион байгуулна.

10.Ширээний теннис:

Тэмцээн эрэгтэй, эмэгтэй нэг бүрчилсэн, холимог хосын төрлөөр явагдана.

Нэг их, дээд сургуулиас эрэгтэй 3, эмэгтэй 2, дасгалжуулагч 1 нийт 6 хүн хүртэл бүрэлдэхүүнтэй оролцож болно. Нэг бүрчилсэн тоглолтууд тойргоор, хос

тоглолт хасагдах системээр явагдана. Тэмцээнийг тухайн спортын олон улсын дүрмийн дагуу зохион байгуулна.

Найм. Шигшээ тэмцээний хуваарь, зохиогдох газар

Наадмын нээлтийн ажиллагаа 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 15.00 цагт Спортын төв ордонд, хаалт буюу нэгдсэн шагнал гардуулах ажиллагаа 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 15.00 цагт Спортын төв ордонд тус тус болно.

№	Спортын төрлүүд	Хугацаа	Зохиогдох байршил
а/. Тэмцээний хугацаа, байршил			
1	Волейбол	2024.04.16-24	ШУТИС болон МУИС спорт заал
2	Гандбол	2024.04.17-21	Буянт Ухаа спортын ордон
3	Жүдо бөх	2024.04.18-19	Баянгол дүүргийн БТСХорооны спорт заал
4	Сагсан бөмбөг 5x5	2024.04.16-25	Спортын төв ордны "А" заал, МУБИС-ийн БТС-ийн заал
5	Таеквондо	2024.04.16-17	Мон-Алтиус БТДС-ийн заал
6	Футзал	2024.04.18-21	МХБХ-ны Футзалын ордон
7	Чирлидинг	2024.04.23	ҮБТДС-ийн спорт заал
8	Чөлөөт бөх	2024.04.20-21	Баянгол дүүргийн БТСХорооны спорт заал
9	Шатар	2024.04.19-21	"Зууны шатар" спорт клуб
10	Ширээний теннис	2024.04.22-24	"Оч" спорт клубийн заал
б/. Спортын эрдэм шинжилгээний бага хурал			
11	Эрдэм шинжилгээний бага хурал	2024.04.18-19	МУИС-ийн Төв номын сан

Их, дээд сургуулийн Спортын эрдэм шинжилгээний бага хурлын сэдэв болон бусад шаардлагын удирдамжийг Монголын оюутны спортын холбооноос гаргаж, удирдан зохион байгуулна.

Энэхүү спортын эрдэм шинжилгээний бага хуралд сургууль тус бүрээс 1 оюутан, 1 багш оролцоно. Шалгарсан оролцогчдод наадмын тусгай шагнал, өргөмжлөл олгоно.

Ес. Дүгнэх журам

9.1. Наадмын зааварт орсон бүх спортын төрлийн тэмцээнийг олон улсын спортын төрлийн дүрэм, энэхүү зааврын дагуу зохион явуулна.

9.2. Наадмын Ерөнхий шүүгчийн зөвлөлийг Монголын Оюутны Спортын холбоо байгуулна.

9.3. Спортын төрөл тус бүрийн тэмцээний багийн дүнг гаргахдаа тухайн баг тамирчдын авсан медалийн тоо, чанарыг харгалзан Спортын холбоо, төрлийн шүүгчдийн зөвлөл нь цуваагаар байр эзлүүлэн дүгнэнэ. Тухайн спортын төрөлд оноо тэнцсэн тохиолдолд авсан медалийн чанар, тоглолтын онооны харьцааг харгалзан эцсийн шийдвэрийг гаргана.

9.4. Спортын холбоодоос ирүүлсэн төрөл тус бүрийн тэмцээний дүн болон байгууллагын дүнг "sport.gov.mn" веб сайтад байршуулна.

9.5. Нэгдсэн дүнг Монголын Оюутны Спортын холбооноос байгуулсан Ерөнхий шүүгчийн зөвлөл гаргаж, наадмын Зохион байгуулах хороонд танилцуулна.

Арав. Наадмын санхүүжилт, шагнал урамшуулал

10.1. Наадмын анхан шатны тэмцээн зохион байгуулах болон шигшээ тэмцээнд шалгарсан баг тамирчдад оролцуулахтай холбоотой нийт зардлыг бүх хэвшлийн их, дээд сургуулийн захиргаа, ивээн тэтгэгчдийн зардлаар санхүүжүүлнэ.

10.2. Наадмын шигшээ тэмцээний медаль, цом, батламж, мандат, шүүгчийн хөлс, мөнгөн шагнал, нээлт, хаалтын урлаг, соёлын арга хэмжээнд шаардагдах зардал зэргийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо нь наадмын төсөвт суулган санхүүжүүлнэ.

10.3. Наадмын шигшээ тэмцээний спортын төрлийн зай, жин тус бүрт эхний гурван байр эзэлсэн баг, тамирчдыг наадмын алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

10.4. Наадмын спортын төрлийн зай, жин тус бүрт эхний гурван байрт шалгарсан баг, тамирчин, дасгалжуулагчдыг наадмын медаль, өргөмжлөл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ын дагуу мөнгөн шагналаар шагнана.

10.5. Наадмын нэгдсэн дүнгээр эхний 1-6 дугаар байр эзэлсэн Их, дээд сургуульд дараах шагналыг олгоно.

- Тэргүүн байр: 6 сая төгрөг, Цом, Батламж, алтан медаль;
- Дэд байр: 5 сая төгрөг, Цом, Батламж, мөнгөн медаль;
- Гуравдугаар байр: 4 сая төгрөг, Цом, Батламж, хүрэл медаль;
- Дөрөвдүгээр байр: 3 сая төгрөг, Батламж;
- Тавдугаар байр: 2 сая төгрөг, Батламж;
- Зургаадугаар байр: 1 сая төгрөг, Батламж.

10.6. Шигшээ тэмцээнийг сайн зохион байгуулан хамтран ажилласан спортын 3 холбоог наадмын батламж, тус бүр 1 сая төгрөгөөр урамшуулна.